

**ЕВРОПЫН ОРНУУДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ
БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН ҮЗЭХ МЭРГЭЖЛИЙН
АЯЛАЛ**

/ Барилгын салбарын мэргэжилтэн, инженерүүдэд зориулагдсан бизнес аялал/

Хамтран зохион байгуулагч: **“Евро трэйвел” ХХК**

Франц, Герман, Чех, Словак, Унгар улсуудад болох барилгын материалын олон улсын үзэсгэлэнгүүдээр зочлох аялал 2018 оны 4-р сарын 6-15 өдрүүдэд зохион байгуулагдах гэж байна.

Энэхүү аялал 9 өдөр, 10 шөнө Европын 5 орноор аялан Герман улсын Нуремберг хотноо болох Сантехник болон халаалт агаар сэлгэлт, сэргээгдэх эрчим хүч, барилгын эрчим хүчний материалын **“IFH INTHERM 2018”**, Словак улсын Братислава хотод болох архитектур дизайн болон барилгын материал, цонх, хаалга, дээвэр, шал, агааржуулагч, цахилгаан суурилуулалт, саун, гаражийн хаалга гэх мэт эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, ухаалаг тоног төхөөрөмжтэй танилцах **“CONECO 2018”**, Унгар улсын Будапешт хотод болох барилгын материалын болон тоног төхөөрөмж, интерьер дизайн, тавилга, амины орон сууцны дизайн, зураг төслийн **“CONSTRUMA 2018”** олон улсын үзэсгэлэнгүүд үзэж сонирхон, Европын орнуудын барилгын орчин үеийн шинэ шийдэл, технологийн дэвшилттэй танилцах юм.

Аялалын хөтөлбөр:

- 4-р сарын 6-нд УБ-Парис нисэх
- 4-р сарын 7-8 нд Парис хоттой танилцах аялал
- 4-р сарын 9-нд Парисаас Германы Нуремберг хот руу явах / 7 цаг 50 мин машинаар/
- 4-р сарын 10 нд Нурембург хотод болж буй “IFH INTHERM 2018” үзэсгэлэнгийн талбайгаар зочлох
- 4-р сарын 11-нд Нуремберг хотоос Чех улсын Прага хот руу явах / 3 цаг 30 мин машинаар/, Праг хотоор аялах, амрах
- 4-р сарын 12-нд Праг хотоос Братислава хот руу явах / 3 цаг 30 мин машинаар/, Братислава хотод болж буй “CONECO 2018” үзэсгэлэнгийн талбайгаар зочлох
- 4-р сарын 13-нд Братислава хотоос Унгар улсын Будапешт хот руу явах /2 цаг 10 мин машинаар/, Будапешт хотод болж буй “CONSTRUMA 2018” үзэсгэлэнгийн талбайгаар зочлох
- 4-р сарын 14-нд Будапешт хоттой танилцах аялал
- 4-р сарын 15-нд Будапешт-УБ нисэх.

Бүртгэл 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийг хүртэл явагдана.

МБИХ-ны Гүйцэтгэх алба

Утас: 330985, 99085635

Цахим шуудан: mace@mace.org.mn

“IFH INTHERM 2018” Үзэсгэлэнгийн тухай:

Герман улсад жил бүр зохион байгуулагддаг энэхүү үзэсгэлэнд дараах чиглэлийн материалуудтай танилцах боломжтой.

- Ариун цэврийн өрөөний сантехникийн материалууд
- Сэргээгдэх эрчим хүч, Халаалтын шийдлүүд / нарны болон цахилгаан халаагуур, дулааны насос/
- Агааржуулалтын систем / Агааржуулагч ба агааржуулалт, хөргөлтийн систем/
- Бусад материалууд / Хаус болон барилгын автоматжуулалт, сантехникийн ххолой, туслах хэрэгслүүд, офис болон барилгын тавилгын тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүд/

“CONECO 2018” Үзэсгэлэнгийн тухай:

Словак улсын Зам ба Барилгын Яам, Хүрээлэн буй орчны Яамнаас зохион байгуулж буй тус үзэсгэлэнд архитектур болон барилгын материалын үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдах ба дараахь чиглэлийн материалууд болон технологитой танилцах боломжтой.

- Барилга үйлдвэрлэлийн материалууд
- Цонх, Хаалга, Дээвэр шалны материалууд
- Халаалт, агаар сэлгэлт, автоматжуулалтын технологи, материал, багаж хэрэгслүүд

“CONSTRUMA 2018” Үзэсгэлэнгийн тухай:

Унгар улсад 36 дахь жилдээ зохион байгуулагдаж буй 19 оны 691 үзэсгэлэнд оролцогчтой Европын хамгийн том барилгын олон улсын үзэсгэлэнд дараахь материал, технологиудтай танилцах боломжтой.

- Архитектур дизайн, интерьер
- Цонх хаалга, шалны материалууд
- Гадна фасадын материалууд / шил, чулуун/
- Дээврийн болон уур ус, дулаан тусгаарлалтын материалууд
- Өндөр технологийн цахилгаан автоматжуулалтын материал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж

Аяллын төлбөр: 1 хүн 2600 евро

Үнэд дараахь зардлууд багтсан:

- (1) Зочид буудал /2-4 одтой/
- (2) Аяллын хөтөлбөрт заасан хоол /өглөөний цай, өдрийн хоол/
- (3) Унаа, жолооч
- (4) Аяллын хөтөч
- (5) Аяллын хөтөлбөрт заасан үзвэр, үйлчилгээ
- (6) 2 талын онгоцны тийз
- (7) Аяллын даатгал
- (8) Визийн хураамж (60 евро)

Үнэд багтаагүй зардлууд:

- (1) Аяллын хөтөлбөрт заагдаагүй хоол, ундаа, согтууруулах ундаа
- (2) Аяллын хөтөлбөрт заагдаагүй нэмэлт үзвэр, үйлчилгээ
- (3) Хувийн хэрэглээний зардлууд

Виз Мэдүүлэхэд Бүрдүүлэх Материалын Жагсаалт /Франц Элчинд/

1) Хүчинтэй Паспорт :

- Мэдүүлж буй визний дуусах хугацаанаас хойш 3 сараас доошгүй хугацаанд хүчинтэй байх,
- Дор хаяж чөлөөтэй хуудас 2-той байх,
- Олгосноос хойш 10 жилээс ихгүй хугацаа өнгөрсөн байх.

2) Бүрэн гүйцэд, үнэн зөв бөглөж, гарын үсэг зурсан Шенгений визний мэдүүлгийн маягт /виз мэдүүлэгч тус бүр/

3) Шаардлага хангасан цээж зураг /цайвар дэвсгэртэй, ойрын үед авахуулсан, 3,5 см X 4,5 см-ийн харьцаатай, эгц урдаас харсан байрлалтай, 2 чих ил гарсан гм. Нүүрний хэмжээ нийт зургийн 70-80%-ийг эзэлсэн байх ёстой/

4) Төрсний гэрчилгээ, Иргэний үнэмлэх (эх хувь, хуулбар)

5) Өмнөх паспортууд (эх хувь + хувийн мэдээлэл агуулсан нүүр хэсэг, сунгалттай болон визтэй хуудаснуудын хуулбар) (хэрэв үрэгдүүлсэн, эсвэл өмнө нь паспорт авч байгаагүй бол Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас лавлагаа авчрах)

6) Гэр бүлийн байдлын харуулсан иргэний бичиг баримт (гэрлэлтийн баталгаа – эх хувь, хуулбар)

7) Дор хаяж 6 сарын хугацаагаар ашигласан банкны дансны хуулга (эх хувь), эсвэл хадгаламжийн дэвтэр (эх хувь, хуулбар)

8) Ажил байдлын тодорхойлолт

ХЭРВЭЭ ТА АЛБАН ГАЗРЫН АЖИЛТАН, ТӨРИЙН АЛБАН ХААГЧ БОЛ :

- Ажилласан жил, цалингийн хэмжээг тусгасан ажил олгогчийн тодорхойлолт, амралт буюу чөлөө олгосон зөвшөөрөл (эх хувь)

ХЭРВЭЭ ТА ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРАЛ БОЛ :

- Байгууллагын гэрчилгээ (эх хувь, хуулбар.), эрхэлж буй үйл ажиллагаатай холбоотой баримт
- Байгууллагын дансны хуулга (эх хувь, хуулбар).